



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Нийслэл, аймгийн статистикийн газар,
хэлтсийн жилийн ажлын үр дүнг үнэлэх
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 дэх заалт, Үндэсний Статистикийн Хорооны Даргын зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн жилийн ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.

Хоёр. Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааны явцад хяналт тавих, шинэчлэн батлагдсан журмын дагуу жил бүр үнэлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Ерөнхий менежер, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга / Т.Гантөмөр /-д үүрэг болгосугай.

Гурав. Журам батлагдсантай холбогдуулан үнэлгээг тооцох, нийтэд ил тод болгох программыг боловсруулж, 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс тогтмол ажиллуулж хэвшүүлэхийг Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга /Л.Мягмарсүрэн/-д даалгасугай.

Дөрөв. Журмын дагуу тайлант хугацааны үйл ажиллагааны хагас жилийн тайланг жил бүр 7 дугаар сарын 9, жилийн эцсийн дэлгэрэнгүй тайланг дүүргийн статистикийн хэлтэс нь Нийслэлийн статистикийн газарт 12 дугаар сарын 10, нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэс 12 дугаар сарын 15-ны дотор Төрийн захиргаа, удирдлагын газарт хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлж, байхыг нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Тав. Дүүргийн статистикийн хэлтсийн жилийн ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх журмыг энэ журамтай уялдуулан ажиллахыг Нийслэлийн статистикийн газрын дарга /Ч.Баянчимэг/-д үүрэг болгосугай.

Зургаа. Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн жилийн ажлын үр дүнг дараах үнэлгээгээр тооцсугай.

- | | | |
|---------------|-------------|----------|
| ✓ 90-100 оноо | "А" үнэлгээ | Маш сайн |
| ✓ 80-89 оноо | "В" үнэлгээ | Сайн |

✓ 70-79 оноо	"С" үнэлгээ	Хангалттай
✓ 60-69 оноо	"D" үнэлгээ	Дутагдалтай
✓ 0-59 оноо	"F" үнэлгээ	Хангалтгүй.


Долоо. Жилийн ажлын үнэлгээний дүнгээр тэргүүлсэн нийслэл, аймгийн статистикийн газар/хэлтсийг өргөмжлөл, 1.0 сая төгрөгөөр, 2 дугаар байр эзэлсэн нийслэл, аймгийн статистикийн хоёр хүртэлх газар/хэлтсийг өргөмжлөл, 700.0 мянган төгрөгөөр, 3 дугаар байр эзэлсэн нийслэл, аймгийн статистикийн хоёр хүртэлх газар/хэлтсийг өргөмжлөл, 500.0 мянган төгрөгөөр, нийслэлийн хэмжээнд тэргүүлсэн дүүргийн статистикийн хэлтсийг 500.0 мянган төгрөгөөр, ажлын үр дүнгээр "А" үнэлгээтэй тооцогдсон нийслэл, аймгийн статистикийн газар/хэлтсийн даргыг Хорооны Даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхийн хүрээнд тус бүр 200.0 мянган төгрөгөөр тус тус шагнаж, урамшуулсугай.

Найм. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2012 оны 01/137 тоот тушаалаар батлагдсан "Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН



**НИЙСЛЭЛ, АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ГАЗАР, ХЭЛТСИЙН ЖИЛИЙН АЖЛЫН
ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЖУРАМ**

**УЛААНБААТАР ХОТ
2014 ОН**

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ
3. ҮЗҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, БАРИМТЛАХ ЗАРЧИМ
4. ТООЦОХ АРГАЧЛАЛ
5. ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ

ХАВСРАЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

- ААНБ – Аж ахуйн нэгж байгууллага
- АХС – Ажиллах хүчний судалгаа
- БХЗГ – Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газар
- ИТХ – Иргэдийн төлөөлөгчдийн хурал
- МБТГ – Мэдээлэл боловсруулалт, технологийн газар
- МССТ – Мэдээлэл, сургалт, сурталчилгааны төв
- МЭЗСГ – Макро эдийн засгийн статистикийн газар
- ӨНЭЗС – Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
- ТЗУГ – Төрийн захиргаа, удирдлагын газар
- ҮСХ – Үндэсний статистикийн хороо
- ХАА – Хөдөө аж ахуй
- ХАНСГ – Хүн ам, нийгмийн статистикийн газар
- ХАӨБ- Хүн ам, өрхийн бүртгэл

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журам нь статистикийн хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн статистикийн салбарын зорилго, зорилт, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтээр нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн жилийн ажлын үр дүнг цогцоор үнэлэхэд чиглэгдэх бөгөөд холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрийг тооцох зарчим, нэгдсэн үр дүнг илэрхийлэхэд түүний зорилго оршино.

1.2. Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн жилийн ажлын үр дүнг үнэлэх журмыг ҮСХ-ны газар, нэгжийн болон нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн санал, зөвлөмжид үндэслэн боловсруулсан болно.

II. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

2.1. “Албан ёсны статистикийн мэдээнд хамруулах аж ахуйн нэгж, байгууллага”-д ҮСХ-ноос тухайн жилд албан ёсны статистикийн мэдээлэл авахаар сонгосон аж ахуйн нэгж, байгууллагыг хамааруулна.

2.2. “Графикт хугацаа” нь ҮСХ-ны даргын тушаалаар баталсан албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн маягтад заагдсан тэдгээрийг цуглуулах, нэгтгэх, дамжуулах хугацаа байна.

2.3. “Шалгуур үзүүлэлт (Ш)” нь нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааны холбогдох үр дүнгийн үнэлгээний үзүүлэлт байна.

2.4. “Үр дүнгийн үзүүлэлт” нь шалгуур үзүүлэлтүүдийн нийлмэл үзүүлэлт бөгөөд үйл ажиллагааны үр дүнгээр нь газар, хэлтсийг эрэмбэлэх итгэлцүүр (коэффициент) болно.

III. ҮЗҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

3.1. Шалгуур үзүүлэлтүүд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 3.1.1 ҮСХ-ны зорилго, зорилтод нийцсэн нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэс жигд хэрэгжүүлэх боломжтой байх;
- 3.1.2 Энгийн, тодорхой, хэмжих боломжтой байх;
- 3.1.3 Нийт орон нутгийн статистикийн албадын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байх;
- 3.1.4 Тайлан, танилцуулга баримтаар баталгаажсан байх;

3.2. Шалгуур үзүүлэлтүүдийг тооцоход баримтлах зарчмууд:

- 3.2.1. Бие даасан, хараат бус байх;
- 3.2.2. Анхдагч мэдээллийн үнэн, бодит байдлыг хангасан байх;
- 3.2.3. Анхдагч мэдээлэл, шалгуур үзүүлэлтийн үр дүн өөр хоорондоо зөрчилгүй, логик уялдаатай байх;
- 3.2.4. Анхдагч мэдээллийн давтамж, эх үүсвэр тодорхой байх;

IV. ТООЦОХ АРГАЧЛАЛ

Энэ хэсэгт нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн жилийн ажлын үр дүнг дараах 4 бүлэг, 16 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх, тооцох аргачлалыг авч үзнэ.

I БҮЛЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМРАЛТ, ДАМЖУУЛАЛТ

- МЭДЭЭНИЙ ХАМРАЛТ (Ш1)
- МЭДЭЭНИЙ ДАМЖУУЛАЛТ (Ш2)
- МЭДЭЭНИЙ БОДИТ БАЙДАЛ, ЧАНАР (Ш3)
- ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш4)
- БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш5)

1. МЭДЭЭНИЙ ХАМРАЛТ (Ш1)

Тайлант хугацаанд мэдээнд хамрагдсан нэгжийн тоог хамрагдвал зохих нийт нэгжийн тоонд харьцуулж хувиар илэрхийлнэ.

$$\text{Ш1} = \frac{\text{Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо}}{\text{Хамрагдвал зохих статистик нэгжийн тоо}} * 100$$

Мэдээнд хамрагдвал зохих статистик нэгжийн тоо: Тухайн жилийн сар, улирал, жилийн мэдээнд хамрагдвал зохих статистик нэгжийн тоо нь бизнес регистрийн санд бүртгэгдсэн нэгжийн нийт тоо бөгөөд жил бүрийн эхэнд жагсаалтаар тодорхойлно.

Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо: Дээрх жагсаалтад үндэслэн мэдээнд хамруулсан статистик нэгжийн тоогоор тооцно.

Хэрэв салбарын мэдээ, тайланд шинээр статистик нэгж нэмж хамруулсан бол тэдгээрийг хамрагдвал зохих болон хамруулсан нэгжийн тоонд оруулж тооцно. Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг Сангийн яам, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэлтэй тулгаж шалгана.

2. МЭДЭЭНИЙ ДАМЖУУЛАЛТ (Ш2)

Жилийн нийт холболтын тоог энэ шалгуур үзүүлэлтэд авбал зохих нийт оноо гэж үзнэ. Хэрэв нэг холболтод нэг, түүнээс дээш мэдээг графикт хугацаанаас хоцроосон бол 1 оноо хасна.

$$\text{Ш2} = \frac{\text{Хоцруулаагүй холболтын тоо}}{\text{Нийт холболтын тоо}} * 100$$

Хоцруулаагүй холболтын тоог нийт холболтын тооноос мэдээ хоцроосон холболтын тоог хасч тооцно.

Жич: Графикт хугацаанд ирүүлсэн ч дараах зөрчил, дутагдал илэрвэл хугацаа хоцроосон гэж үзэж оноог хасч тооцно. Үүнд:

- ✓ *ҮСХ-ноос боловсруулсан программаар мэдээ тайлангийн үзүүлэлтийг шивээгүй байх;*

- ✓ Хоосон файл ирүүлэх;
- ✓ Файлын нэр, агуулга, шифр зөрүүтэй (өмнөх сарын мэдээ зэрэг) файл ирүүлэх;
- ✓ Буруу хаяг (хувийн) -аар ирүүлэх;
- ✓ Тайлант хугацаа зөрүүтэй

3. МЭДЭЭНИЙ БОДИТ БАЙДАЛ, ЧАНАР (ШЗ)

Мэдээний бодит байдал, чанарыг эдийн засгийн болон өрх, хүн ам, нийгмийн статистикийн мэдээ, тайланд илэрсэн алдаагаар төлөөлүүлэн хэмжинэ.

$$\text{ШЗ} = 100 - \sum(\text{Жин} * \text{харгалзах алдааны нийт тоо})$$

№	Алдааны төрөл	Жин
1	Логик (үзүүлэлт хоорондын уялдаа)	0.067
2	Үзүүлэлт дутуу нөхөх	0.067
3	Үзүүлэлтийг орон, цэг, таслалын алдаатай шивэх	0.100
4	Үзүүлэлтийг маягтад заасан хэмжих нэгжээр тооцож ирүүлээгүй	0.100
5	Үзүүлэлтийг тайлбаргүйгээр хэт зөрүүтэй ирүүлэх (өссөн/буурсан)	0.133
6	Балансын алдаа	0.067
7	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүтээгдэхүүн үйлчилгээ, ажил мэргэжлийн болон бусад ангиллын кодыг буруу нөхөх	0.200
8	Мэдээ, тайланг нэгтгэснээс хойш болон нийтэд зарлагдсан мэдээлэлд залруулга хийх	0.266

Мэдээ, тайлангийн тодруулга, залруулга, тайлбарыг todruulga@nso.mn хаягаар ирүүлнэ.

4. ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш4)

ХАӨБ-ийн мэдээллийн санг дараа оны 1 дүгээр сарын 4-ний өдрөөр тасалбар болгож, "Суурин хүн амын 20.. оны жилийн эцсийн тайлан (ХА-3)" мэдээтэй тулгалт хийж оноог өгнө.

- ✓ ХА-3 мэдээний хүн амын тоо А1,
- ✓ Мэдээллийн санд байгаа суурин хүн амын тоо А2.
- ✓ ХА-3 мэдээний өрхийн тоо В1,
- ✓ Мэдээллийн санд байгаа өрхийн тоо В2.
- ✓ Мэдээллийн санд тухайн хүний талаархи мэдээллийг бүрэн шивж оруулсан тохиолдолд хүний тоо алдаагүй гэж үзээд В1,
- ✓ Алдааны хувь $V1/A2*100$

Нийт хувийг дараах байдлаар тооцно.

$$\text{Ш4} = \left(\frac{A2}{A1} * 100 + \frac{B2}{B1} * 100 + \frac{B1}{A2} * 100 \right) / 3$$

5. БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш5)

Албан ёсны статистикийн жилийн мэдээний хамралтын хувийг харгалзан бизнес регистрийн мэдээллийн сангийн оноог өгнө. Мэдээ ирүүлсэн ААНБ-ын тоо, хамралтад оруулж тооцох нэгжийн тооны нийлбэрийг ирүүлбэл зохих статистик нэгжийн тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ш5} = \frac{\text{Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо}}{\text{Хамрагдвал зохих статистик нэгжийн тоо}} * 100$$

Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтэс 2015 оноос эхлэн бизнес регистрийн нэгдсэн мэдээллийн санд орох өөрчлөлт, хөдөлгөөн, баяжилтыг өөрсдөө хариуцан тусгана. Иймд бизнес регистрийн мэдээллийн сангийн үнэлгээг дараах байдлаар хийнэ.

$$\text{Ш5} = \frac{\text{Ш5.1} + \text{Ш5.2}}{2} * 100$$

1. Баяжилт хийсэн байдал

Бизнес регистрийн мэдээллийн сангийн баяжилтад шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан хувийн жингээр тооцно.

$$\text{Ш5.1} = \frac{\text{Тайлант хугацаанд БР – ийн санд нэмэгдсэн ААНБ – ын тоо}}{\text{Шинээр байгуулагдсан ААНБ – ын тоо}}$$

2. Өөрчлөлт, хөдөлгөөнийг тусгасан байдал

Тайлант хугацаанд статистикийн сар, улирал, жилийн мэдээнд хамрагдахгүй байгаа ААНБ, түүний салбар нэгжийн үйл ажиллагаа эрхлэлтийн байдал, хаяг, үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тоог шинэчилсэн байдлаар дүгнэнэ.

$$\text{Ш5.2} = \frac{\text{Тайлант хугацаанд БР – ийн санд шинэчлэлт хийгдсэн ААНБ – ын тоо}}{\text{Мэдээ, тайланд хамрагдаагүй ААНБ – ын тоо}}$$

Тайлант хугацаанд БР-ийн санд шинэчлэлт хийгдсэн ААНБ-ын мэдээллийг албан ёсны статистикийн жилийн мэдээ, Сангийн яам, Татварын ерөнхий газрын мэдээлэлтэй тулгаж, шалгана.

II БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

- МАЛ ТООЛЛОГО (Ш6)
- ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА (Ш7)
- АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА (Ш8)
- ЭДИЙН ЗАСГИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА (Ш9)

6. МАЛ ТООЛЛОГО (Ш6)

Жилийн эцсийн мал тооллогын ажлыг дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

- Бэлтгэл ажил, зохион байгуулалт
- Мэдээллийг батлагдсан аргачлал, заавар, журмын дагуу чанартай гүйцэтгэсэн байдал (Мэдээллийн чанар)
- Мэдээлэл дамжуулалт (графикт хугацаанд)

ШБ = Бэлтгэл ажил + Мэдээллийн чанар + Мэдээлэл дамжуулалт

А) Тооллогын бэлтгэл зохион байгуулалтын ажлыг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд тайланд тодорхой тусгасан байна. Нийт 30 оноо

А.1 Тооллогын бэлтгэл ажил - 15 оноо

Мал тооллогын бэлтгэл ажлыг дараах үзүүлэлтүүдээр үнэлэн дүгнэнэ. Үүнд:

Үзүүлэлтүүд	Хангасан байдал		
	Бүрэн	Дунд	Муу
Мал тооллогын комисс байгуулсан захирамж (аймаг/нийслэл) гаргасан болон орон нутгийн төсөө (аймаг/нийслэл)-т мал тооллогын зардлыг нэр зааж батлуулсан эсэх.	5	3	0
Мал тооллогын хяналт хийх төлөвлөгөө, удирдамж, чиглэлийг (аймаг/нийслэл)-ийг тогтоож, сургалт зохион байгуулсан эсэх.	5	3	0
Мал тооллогын мэдээлэл боловсруулах программын бэлтгэл хангагдсан, сумын түвшиний мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв гаргаж, дамжуулсан эсэх.	5	3	0

Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсээс мал тооллогын тайланг сум/дүүргийн дүнгээр нэгтгэн аймаг, нийслэлдээ дүгнэж, аймаг нийслэлийн дүнгээр ҮСХ-нд ирүүлнэ.

А.2 Тооллогын хяналт - 15 оноо

Мал тооллогоор тоологдсон нийт өрх, ААНБ болон хяналтын тооллогод хамрагдсан өрх, ААНБ-ын хамралтыг харгалзан дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

$$\text{Хамралт} = \frac{\text{Хяналтын тооллогод хамрагдсан өрх, ААНБ} - \text{ын тоо}}{\text{Тооллогод хамрагдсан өрх, ААНБ} - \text{ын тоо}} * 100\%$$

Хамралт	Оноо
10.0% +	15
8.0% - 9.9%	10
5.0% - 7.9%	5
<5.0%	0

Б) Тооллогын мэдээллийн чанарыг дараах байдлаар үнэлнэ. Авбал зохих дээд оноо 60 байх бөгөөд дараах төрлийн алдааг гаргасан тохиолдолд алдаа тооцно. Алдааны тоо нь

хамрагдвал зохих өрх, ААНБ-ын тооноос илүү гарсан тохиолдолд чанарын оноог 0-ээр тооцно.

$$\text{Чанар} = 60 * \left[1 - \frac{\text{Алдааны тоо}}{\text{Хамрагдвал зохих өрх, ААНБ - ын тоо}} \right]$$

- ✓ Логик (үзүүлэлт хоорондын уялдаа), балансын алдаа
- ✓ Үзүүлэлт дутуу нөхөх
- ✓ Үзүүлэлтийг орон, цэг, таслалын алдаатай шивэх
- ✓ Үзүүлэлтийг маягтад заасан хэмжих нэгжээр тооцож ирүүлээгүй
- ✓ Үзүүлэлтийг тайлбаргүйгээр хэт зөрүүтэй ирүүлэх (өссөн/буурсан)
- ✓ Ангиллын кодыг буруу нөхөх
- ✓ Том малын зүй бус хорогдол, мал төллөлт, төл бойжилтын явцын мэдээнээс 15 хувиас илүү зөрүүтэй /байгалийн гамшигт үзэгдэл болон мал амьтны гаралтай халдварт өвчний шалтгаанаас бусад тохиолдолд/
- ✓ Малтай өрх болон малчин өрхийн тоо өмнөх оныхоос үндэслэлгүй өөрчлөгдсөн.
- ✓ Оны эхний мал, хээлтэгч малын өмнөх оны жилийн эцсийн дүн тухайн оны эхний дүнтэй зөрүүтэй байх
- ✓ Мэдээ, тайланг нэгтгэснээс хойш болон нийтэд зарлагдсан мэдээлэлд залруулга хийх

В) Тооллогын мэдээллийн дамжуулалтыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$\text{Дамжуулалт} = 10 - \text{Хугацаа хоцроосон хоногийн тоо} * 5$$

Авбал зохих 10.0 оноо. Хоёр, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд 0.0 оноо өгнө.

7. ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА (Ш7)

ӨНЭЗС-ны ажлыг дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

- Хамралт
- Мэдээллийн чанар
- Мэдээлэл дамжуулалт

$$\text{Ш9} = \text{Хамралт} + \text{Мэдээллийн чанар} + \text{Мэдээлэл дамжуулалт}$$

А) Түүвэр судалгааны хамралтыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$\text{Хамралт} = 30 - \left(\frac{\text{Нөөц өрхийн тоо}}{\text{Хамрагдвал зохих өрхийн тоо}} \right) - \text{СХӨТ}$$

СХӨТ-Судалгаанд хамруулаагүй өрхийн тоо

Б) Мэдээллийн чанарыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$\text{Чанар} = 60 * \left[1 - \frac{\text{Алдааны тоо}}{\text{Хамрагдвал зохих өрхийн тоо}} \right]$$

Аль ч аймгийн хувьд алдааны тоо нь хамрагдвал зохих өрхийн тооноос илүү гарсан тохиолдолд чанарын оноо шууд 0-тэй тэнцүү байна.

В) Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалтыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$\text{Дамжуулалт} = 10 - \text{Хугацаа хоцроосон хоногийн тоо} * 3$$

Авбал зохих 10.0 оноо. Дөрөв, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд 0.0 оноо авна.

8. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА (Ш8)

АХС-ны ажлыг дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

- Хамралт
- Мэдээллийн чанар
- Мэдээлэл дамжуулалт

$$\text{Ш10} = \text{Хамралт} + \text{Мэдээллийн чанар} + \text{Мэдээлэл дамжуулалт}$$

А) Түүвэр судалгааны хамралтыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$\text{Хамралт} = 30 - \left(\frac{\text{Нөөц өрхийн тоо}}{\text{Хамрагдвал зохих өрхийн тоо}} \right) - \text{СХӨТ}$$

СХӨТ- Судалгаанд хамруулаагүй өрхийн тоо

Б) Мэдээллийн чанарыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$\text{Чанар} = 60 * \left[1 - \frac{\text{Алдааны тоо}}{\text{Хамрагдвал зохих өрхийн тоо}} \right]$$

Аль ч аймгийн хувьд алдааны тоо хамрагдвал зохих өрхийн тооноос илүү гарсан тохиолдолд чанарын оноо шууд 0-тэй тэнцүү байна.

В) Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалтыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$\text{Дамжуулалт} = 10 - \text{Хугацаа хоцроосон хоногийн тоо} * 3$$

Авбал зохих 10.0 оноо. Дөрөв, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд 0.0 оноо авна.

9. ЭДИЙН ЗАСГИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА (Ш9)

Эдийн засгийн түүвэр судалгааны дүнг тухайн жилд явагдсан судалгаануудын үнэлгээний дунджаар тооцно. Судалгааг өрхөд суурилсан, ААНБ-ын түүвэр судалгаа гэж ангилж дүгнэнэ.

1. Өрхөд суурилсан эдийн засгийн түүвэр судалгааны хувьд ӨНЭЗС-тай адил зарчмаар дүгнэнэ.

2. ААНБ-ын түүвэр судалгааг дараах байдлаар дүгнэнэ.

ЭЗТС-ны ажлыг дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

- Хамралт
- Мэдээллийн чанар
- Мэдээлэл дамжуулалт

$Ш11 = \text{Хамралт} + \text{Мэдээллийн чанар} + \text{Мэдээлэл дамжуулалт}$

А) Түүвэр судалгааны хамралтыг дараах томъёоллын дагуу тооцно.

$\text{Хамралт} = 30 * \frac{\text{Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо}}{\text{Хамрагдвал зохих нийт статистик нэгжийн тоо}}$

Б) Мэдээллийн чанарыг ШЗ-тай адил дүгнэнэ. Уг үзүүлэлтийн хувьд авбал зохих нийт оноо нь 60.0 байна.

В) Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалтыг дараах томъёоллын дагуу тооцно.

$\text{Дамжуулалт} = 10 - \text{Хугацаа хоцроосон хоногийн тоо} * 3$

Авбал зохих 10.0 оноо. Дөрөв, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд 0.0 оноо авна.

Ш БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

- СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш10)
- СУРТАЛЧИЛГАА (Ш11)
- ВЭБ БАЯЖИЛТ (Ш12)
- МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ (Ш13)

10. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш10)

Сургалтын үйл ажиллагааг дараах томъёолол (бүрдэл хэсэг)-ын дагуу тооцно.

$Ш12 = \text{БХСС} + \text{СС} + \text{ИДСС} + \text{ЕБСС} + \text{БСС}$

БХСС – Баг, хороо/сумдын статистикийн мэдээ хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт

СС – Судалгааны үйл ажиллагаатай холбогдох сургалт

ИДСС – Их, дээд сургууль, коллеж/Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын төв

ЕБСС – Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан хичээл

БСС – Бизнесийн салбарын ажилтнуудад зориулсан сургалт

А) Баг, хороо/сумдын статистикийн мэдээ хариуцсан (баг, хорооны Засаг дарга нар, сумдын төрийн сангийн төлөөлөгч) ажилтнуудад зориулсан сургалтыг жил бүр ээлжлэн зохион байгуулж, тайланг шалгуур үзүүлэлт бүрийн холбогдох хавсралтын хамт ажлын 5 хоногт багтаан МССТ-д ирүүлнэ.

Ирц : Хамралт 0.0-5.0 оноо (Тухайн аймгийн баг, хороо/сумдын тоогоор хамралтыг тооцно.)

$$\text{Хамралт} = 5 \text{ оноо} * \frac{\text{Хамрагдсан оролцогчдын тоо}}{\text{Хамрагдах оролцогчдын тоо}}$$

Хичээлийн сэдэв: 5.0 оноо

№	Сэдвийн шалгуур үзүүлэлт	Оноо
1	Статистикийн салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг	0.5
2	Хүн ам, нийгмийн статистикийн мэдээ гаргах аргачлал, заавар	0.8
3	Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр нөхөх заавар	0.8
4	Хүн ам, өрхийн бүртгэлийн програмын агуулга, заавар	0.8
5	Монгол “Улсын Статистикийн тухай” хуулийг хэрэгжүүлэхэд баг, хороо/сумдын статистикийн мэдээ хариуцсан ажилтнуудын үүрэг, оролцоо	0.5
6	Хөдөө аж ахуйн салбарын статистикийн мэдээ, тайлан гаргах аргачлал заавар	0.8
7	Мал тооллого	0.8

Тухайн хугацаанд тайлан ирүүлээгүй бол – 0.0 оноо

Б) Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн дагуу ҮСХ-ноос тухайн жилд зохион байгуулсан судалгааны (ҮСХ-нд зохион байгуулсан сургалтыг оруулахгүй) сургалтыг зохион байгуулж, тайланг хавсралтын хамт ажлын 5 хоногт багтаан МССТ-д ирүүлнэ.

Хамралт : 0.0-5.0 оноо

$$\text{Хамралт} = 5 \text{ оноо} * \frac{\text{Хамрагдсан оролцогчдын тоо}}{\text{Хамрагдах оролцогчдын тоо}}$$

Сургалтын материал:

ҮСХ-ноос зохион байгуулж байгаа нэгжээс өгөгдсөн сургалтын сэдвийн агуулгаас хамааруулан 0.0 - 5.0 оноо,

Сэдэв бүрэн 5.0 оноо

Сэдэв дутуу 3.0 оноо

Тухайн хугацаанд тайлан ирүүлээгүй бол – 0.0 оноо

В) Статистикийн мэдээллийг хэрэглэгч зорилтот бүлгүүдийн сургалт нь 3 төрөлтэй байна. Үүнд:

1. Нийслэл, аймгийн их, дээд сургууль, коллеж/Техникийн болон мэргэжлийн боловсролын төвийн оюутнуудад зориулсан “Статистикийн тухай” хууль болон статистикийн салбарын болон өөрийн газар, хэлтсийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх сургалт
2. Нийслэл, аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан “Статистикийн боловсрол” сэдэвт сургалт
3. Статистикийн анхдагч мэдээллийг гаргагч аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт (жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах)

Дээрх 3 төрлийн сургалт бүрт 10.0 оноо өгнө. Дараах шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

<i>№</i>	<i>Шалгуур үзүүлэлт</i>	<i>Оноо</i>
1	<i>Тухайн сургалтын хичээлийн сэдэв</i>	5.0
2	<i>Оролцогчдын хамралт</i>	1.5
3	<i>Сургалтад тараасан материал</i>	1.5
4	<i>Оролцогчдоос авсан санал асуулгын дүн</i>	1.0
5	<i>Сургалтын үйл явцын зураг</i>	1.0

Сургалтыг зохион байгуулж, тайланг шалгуур үзүүлэлт бүрийн холбогдох хавсралтын хамт ажлын 5 хоногт багтаан МССТ-д ирүүлнэ.

Тухайн хугацаанд тайлан ирүүлээгүй бол – 0.0 оноо

11. СУРТАЛЧИЛГАА (Ш11)

Сурталчилгааны үйл ажиллагааг дараах томъёолол (бүрдэл хэсэг)-ын дагуу тооцно.

$$\text{Ш13} = \text{ХБХ} + \text{ТСС} + \text{ХСМСС} + \text{ХБСҮАС}$$

ХБХ - Хэвлэлийн бага хурал

ТСС – Тооллого, судалгааны сурталчилгаа

ХСМСС – Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийн санг сурталчлах

ХБСҮАС – Хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчлах

А) Сар бүр статистикийн мэдээллээр хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, сонин хэвлэлд нийтлүүлсэн материалыг хавсаргасан тайланг улирал бүр ирүүлнэ. /ҮСХ-ны албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны дүнг тархаах хуваарьт заасан хэвлэлийн бага хурлыг товлосон өдрийн 11:00 цагт орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

Жич: НСГ нь хэвлэлийн бага хурлыг хийх шаардлагагүй, сонин, хэвлэлд сурталчилсан байдлаар үнэлнэ.

$$\text{ХБХ} = \text{Хэвлэлийн бага хурал хийсэн тоо} * \frac{20.0 \text{ оноо}}{12 \text{ удаа}}$$

Б) Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйл, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу ҮСХ-ноос тухайн жилд зохион байгуулж байгаа тооллого, судалгааны талаар улирал тутам мэдээлэл бэлтгэж, сурталчлах бөгөөд тайланг ажлын 3 хоногт багтаан МССТ-д ирүүлнэ.

$$TCC = \text{Тооллого судалгааны ажлыг сурталчилсан тоо} * \frac{10.0 \text{ оноо}}{4 \text{ (улирал)}}$$

В) Интернет хэрэглэдэг хэрэглэгчдэд статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайт, EzStat, MonStat аппликейшн, интернетгүй хэрэглэгчдэд DevInfo сангийн хэрэглээг сард 1 удаа сурталчлах

$$XCMCC = \text{Мэдээллийн санг сурталчилсан тоо} * \frac{10.0 \text{ оноо}}{12 \text{ удаа}}$$

Г) “Статистикийн тухай” хууль болон статистикийн салбарын болон газар, хэлтсийнхээ үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг аймгийнхаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр улиралд 1 удаа сурталчлах бөгөөд тайланг ажлын 5 хоногт багтаан МССТ-д ирүүлнэ.

$$XBCYAC = \text{Салбарын үйл ажиллагааг сурталчилсан тоо} * \frac{10.0 \text{ оноо}}{4 \text{ удаа}}$$

12. ВЭБ БАЯЖИЛТ (Ш12)

ВЭБ баяжилтын үйл ажиллагааг дараах байдлаар тооцно.

$$Ш12 = BT + БюТ + ШММ + НЭЗБ$$

BT - Байгууллагын танилцуулга

БюТ - Бюллетень, танилцуулга

ШММ - Шинэ мэдээ, мэдээлэл

НЭЗБ - Нийгэм, эдийн засгийн байдал

А) Байгууллагын танилцуулга - Тухайн газар, хэлтэс өөрийн байгууллагын танилцуулга болон түүхэн замналыг тухайн жилдээ 1-р улиралд багтаан шинэчлэн оруулсан байна.

$$BT \begin{cases} \text{Оруулсан тохиолдолд} - & 25 \text{ оноо} \\ \text{Оруулаагүй тохиолдолд} - & 0 \text{ оноо} \end{cases}$$

Б) Бюллетень, танилцуулга - Сарын бюллетень, танилцуулгыг сар бүрийн 15-ны дотор газар, хэлтсийнхээ вэб хуудсанд оруулсан байна. Өмнөх оны эцсийн болон тайлант оны эхний 11 сарын байдлаар нийт 12 удаа бюллетень, танилцуулга бэлтгэн байршуулсан байна.

$$БюТ = \text{Бюллетень, танилцуулга вэб сайтад байршуулсан удаа} * \frac{25.0 \text{ оноо}}{12 \text{ удаа}}$$

В) Шинэ мэдээ, мэдээлэл - Сарын мэдээллээр хийх хэвлэлийн бага хурлын илтгэлийн файлыг сар бүрийн 15-ны дотор вэб хуудсандаа оруулсан байна. Өмнөх оны жилийн эцсийн болон тайлант оны эхний 11 сарын байдлаар нийт 12 удаа илтгэл бэлтгэн байршуулсан байна.

$$\text{ШММ} = \text{Бага хурлын илтгэлийн файлыг байршуулсан удаа} * \frac{25.0 \text{ оноо}}{12 \text{ удаа}}$$

Сарын мэдээллээр хийх хэвлэлийн бага хурлын презентацийн загварыг www.1212.mn сайтын “Сарын мэдээний презентаци” булангаас ашиглана.

Г) Нийслэл, аймгийн статистикийн үзүүлэлт - Газар, хэлтэс өөрийн аймгийн хүн ам, малын тоо, тариалсан талбай, хураасан ургац зэрэг үзүүлэлтийг сум, багаар 2000 оноос хойших онуудаар динамик бүрдүүлж, жил бүрийн эхний улиралд оруулсан байна.

$$\left\{ \begin{array}{l} I \text{ улирал} - 15 \text{ оноо} \\ II \text{ улирал} - 10 \text{ оноо} \\ III \text{ улирлаас хойш} - 0 \text{ оноо} \end{array} \right. +$$

Салбарын мэдээллээр сүүлийн 5 оноор сар, улирал жилээр инфографик бүхий мэдээлэл бэлтгэн улирал тутам оруулах. /Эрүүл мэнд, Гэмт хэрэг, Нийгмийн даатгал халамж, Төсөв, Аж үйлдвэр, Хөдөө аж ахуй/

$$+ \left\{ \begin{array}{l} 5, \text{ түүнээс дээш салбар} - 10 \text{ оноо} \\ 4 \text{ салбар} - 8 \text{ оноо} \\ 3 \text{ салбар} - 6 \text{ оноо} \\ 2 \text{ салбар} - 4 \text{ оноо} \\ 1 \text{ салбар} - 2 \text{ оноо} \end{array} \right.$$

Жич: Статистикийн мэдээ, мэдээлэлд УСХ-ны Даргын 2013 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 1/137 тоот тушаалаар баталсан салбарын логог ашиглана.

13. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ (Ш13)

Үнэлгээг өгөхдөө мэдээлэл тархаалтын хугацаа, чанарыг харгалзана.

$$\text{Ш15} = \sum \left(\frac{\text{Тархаасан тоо}}{\text{Нийт тархаавал зохих тоо}} * \text{Авбал зохих оноо} \right)$$

Заагдсан хугацаанаас 10 хоног хоцроож тархаасан тохиолдолд 0.0 оноо өгнө.

✓ Сар бүрийн бюллетень, танилцуулга тархаах

Авбал зохих оноо: 20.0 оноо

Тархаах хугацаа: Сар бүрийн 15

Тархаах : 12 удаа

✓ Нийслэл, аймгийн статистикийн жилийн эмхэтгэл тархаах

Авбал зохих оноо: 20.0 оноо

Тархаах хугацаа: 6 сарын 20

Тархаах: 1 удаа

- ✓ ҮСХ-ноос жил бүр гаргадаг Монгол Улсын статистикийн эмхэтгэл
 - Авбал зохих оноо: 20.0 оноо*
 - Тархаах хугацаа: 7 сарын 1*
 - Тархаах тоог ҮСХ-ны Ерөнхий менежер жил бүр батална.*
- ✓ Хөдөө аж ахуйн салбарын танилцуулгыг тархаах
 - Авбал зохих оноо: 10.0 оноо*
 - Тархаах хугацаа: 4 сарын 1*
 - Тархаах: 1 удаа*
- ✓ Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүдийн төлөв, байдал танилцуулгыг тархаах
 - Авбал зохих оноо: 10.0 оноо*
 - Тархаах хугацаа: 5 сарын 1*
 - Тархаах: 1 удаа*
- ✓ Ажил эрхлэлтийн байдал танилцуулгыг тархаах
 - Авбал зохих оноо: 10.0 оноо*
 - Тархаах хугацаа: 6 сарын 25*
 - Тархаах: 1 удаа*
- ✓ Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулгыг тархаах
 - Авбал зохих оноо: 10.0 оноо*
 - Тархаах хугацаа: 6 сарын 15*
 - Тархаах: 1 удаа*

Тайланд мэдээллийг тархаасан талаарх танилцуулга болон тархаасан жагсаалтын хувийг хавсарган тархаасан хугацаанаас хойш 3 хоногийн дотор МССТ-д ирүүлнэ.

IV БҮЛЭГ. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, ТӨСӨВТ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, АШИГЛАЛТ

- ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ӨГӨӨЖ (Ш14)
- ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ (Ш15)
- ТӨСӨВТ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, АШИГЛАЛТ (Ш16)

14. ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ (Ш14)

Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, салбарын хүний нөөцийн мэдээллийн сангийн баяжилт болон өөрсдийн нөхцөл бололцоог ашиглан ажилтнуудынхаа ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал, ҮСХ-нд дамжуулж буй цаг үеийн мэдээ тайлангийн ирцийг харгалзан дүгнэж, оноог өгнө.

- Үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг нийслэл, аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргаар батлуулж жил бүрийн 2 сарын 1-ний дотор, биелэлтийг жил бүрийн 6 сарын 30, жилийн эцсийн тайлангийн хамт төлөвлөгөөний заалт бүрээр гарган баримтжуулж, ирүүлсэн байдлыг харгалзан **0-20 оноо**

- ✓ Батлагдсан төлөвлөгөөг ирүүлсэн бол **5.0 оноо**
- ✓ Төлөвлөгөөний биелэлт **0-15.0 оноо**

$$\text{Төлөвлөгөөний биелэлт} = 15 \text{ оноо} * \frac{\text{Хэрэгжсэн ажил, үйлчилгээний тоо}}{\text{Төлөвлөсөн ажил, үйлчилгээний тоо}}$$

- ✓ Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь биелүүлээгүй, хугацаа хожимдуулж хэрэгжүүлсэн, төлөвлөгөө, биелэлтийг хугацаа хожимдуулж ирүүлсэн, баримт нотолгоо дутуу бол **0.0 оноо**
- Өөрсдийн санаачилгаар ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдлыг харгалзан **20 оноо**
 - ✓ Баримтжуулсан тайланг ирүүлсэн **20.0 оноо**
 - ✓ Огт тайлан ирүүлээгүй **0.0 оноо**

- Хүний нөөцийн мэдээллийн сангийн баяжилт **0-30 оноо**

Мэдээллийн сангийн баяжилтад улирал бүр хяналт, шалгалт хийж, мэдээллийг бүрэн оруулсан байдал, алдаатай эсэхийг харгалзан тохирох оноог өгнө.

I улирал	/3 сарын 30/
II улирал	/6 сарын 30/
III улирал	/9 сарын 30/
IV улирал	/12 сарын 30/

- ✓ Мэдээлэл бүрэн, алдаагүй бол **7.5 оноо (улирал бүр)**
- ✓ Хугацаа хоцроосон, баяжилтыг огт хийгээгүй, мэдээллийг дутуу оруулсан, алдаатай тохиолдолд **0.0 оноо**
- Цаг үеийн шаардлагаар ирүүлэх мэдээлэл, тайлангийн хугацааг харгалзан **0-30 оноо**

$$\text{ЦҮШИМТХ хугацаа} = 30.0 \text{ оноо} * \frac{\text{Ирүүлсэн мэдээ, тайлангийн тоо}}{\text{Ирүүлбэл зохих мэдээ, тайлангийн тоо}}$$

ЦҮШИМТХ – Цаг үеийн шаардлагаар ирүүлэх мэдээ, тайлангийн хугацаа

15. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ӨГӨӨЖ (Ш15)

Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааны тайлан, статистикийн улсын байцаагчдын ажлын тайланг тус тус үндэслэн дараах 3 үндсэн бүрэлдэхүүн хэсгээр хяналт, үнэлгээний үр дүнг үнэлнэ.

1. Бие даан мэдээ, тайлангийн гаргалт, түүний бодит байдал, бүртгэл, тооллого, судалгааны явц, үр дүнд хийсэн хяналт, шалгалтын дүнг мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, өрхөд суурилсан судалгаа, тооллогын явцын хяналт шалгалтад **0-35 оноогоор**

<i>ААНБ /20%/</i>	<i>ААНБ-ын тоо</i>	<i>нийт 7 оноо</i>
	<i>0-10</i>	<i>3</i>
	<i>11-20</i>	<i>4</i>
	<i>21-30</i>	<i>5</i>
	<i>31-40</i>	<i>6</i>
	<i>41+</i>	<i>7</i>
<i>Өрхөд суурилсан /60%/</i>	<i>Өрхийн тоо</i>	<i>нийт 21 оноо</i>
	<i>0-20</i>	<i>12</i>
	<i>21-30</i>	<i>15</i>
	<i>31-40</i>	<i>18</i>
	<i>41+</i>	<i>21</i>
<i>Тооллого, судалгаа /20%/</i>	<i>Өрхийн тоо</i>	<i>нийт 7 оноо</i>
	<i>0-10</i>	<i>3</i>
	<i>11-20</i>	<i>4</i>
	<i>21-30</i>	<i>5</i>
	<i>31-40</i>	<i>6</i>
	<i>41+</i>	<i>7</i>
<i>Нийт оноо</i>	<i>0-35.0 оноо</i>	

2. Бусад байгууллагатай хамтран мэдээ, тайлангийн гаргалт, түүний бодит байдал, бүртгэл, тооллого, судалгааны явц, үр дүнд хийсэн хяналт, шалгалтын дүнг тухайн аймгийн Тамгын газрын холбогдох хэлтэс, албад болон орон нутгийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын статистикийн улсын байцаагч нартай тус тус хамтран хийсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо, тэдгээрт гарсан зөрчил, зөрчлийг арилгасан байдлаар **0-40 оноогоор**;

<i>Аж ахуйн нэгж байгууллага</i>	<i>ААНБ-ын тоо</i>	<i>нийт 40 оноо</i>
	<i>0-30</i>	<i>25</i>
	<i>31-60</i>	<i>30</i>
	<i>61-90</i>	<i>35</i>
	<i>91+</i>	<i>40</i>
<i>Нийт оноо</i>	<i>0-40.0 оноо</i>	

3. Хяналт, шалгалтын мөрөөр сайжруулсан ажлыг үнэлэхдээ аж ахуйн нэгж, байгууллагын мэдээний хамралт, мэдээ хоцролтыг арилгах, анхан шатны бүртгэл хөтлөлтийг сайжруулсан байдлаар **0-25 оноогоор** үнэлнэ.

<i>Мэдээ ирүүлдэггүй байсан ААНБ-аас мэдээ авч хэвшүүлсэн байдал</i>	<i>ААНБ-ын тоо</i>	<i>нийт 10 оноо</i>
	<i>0-10</i>	<i>6</i>
	<i>11-20</i>	<i>8</i>
	<i>21+</i>	<i>10</i>
<i>Хожимдсон мэдээ хугацаанд нь өгдөг болсон</i>	<i>7</i>	
<i>Анхан шатны бүртгэл хөтлөлтийг сайжруулсан</i>	<i>8</i>	
<i>Нийт оноо</i>	<i>0-25.0 оноо</i>	

16. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш16)

Төсөвт хөрөнгийн зарцуулалт, тайлагналт, аудитын дүгнэлт зэргийг харгалзан дүгнэнэ.

1. Санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, хуулийн хугацаанд ирүүлсэн байдлыг харгалзан 0-36.0 оноо

№	Шалгуур үзүүлэлт	Иж бүрэн, хугацаандаа, үнэн зөв	Алдаатай тайлан	Хугацаа хожимдуулсан, тайлан гаргаагүй
1	Санхүүгийн байдлын тайлан	5	3	0
2	Санхүүгийн үр дүнгийн тайлан	5	3	0
3	Өмчийн өөрчлөлтийн тайлан	5	3	0
4	Мөнгөн гүйлгээний тайлан	5	3	0
5	Шалгах баланс /аккурэль болон мөнгөн суурьт/	5	3	0
6	Төсвийн гүйцэтгэлийн тайлан /цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын ангиллаар/	5	3	0
7	Тодруулгат тайлан, (Үндсэн хөрөнгө, бараа материал, өглөг, авлага, орон тоо, цалингийн сангийн тайлан)	6	3	0

2. Санхүүгийн стандарт программын хэрэглээ /Сангийн яамны зөвшөөрөлтэй Acolous 3.0 санхүүгийн программаар гаргасан байдлыг харгалзан үнэлнэ / 0 -15.0 оноо/.

- ✓ Өмнөх оны жилийн эцсийн болон тайлант оны 2 улирлын тайланг программаараа гаргаж ирүүлсэн 15.0 оноо
- ✓ Санхүүгийн стандарт программ ашиглан гаргаагүй бол 0.0 оноо

3. Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн тайлан /Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөлт, жилийн эцсийн тооллогын бүртгэл, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт/ 0-5.0 оноо

Хугацаа: дараа оны 2 сарын 25-ны дотор ҮСХ-ны санхүүд ирүүлнэ.

- ✓ Тайланг ирүүлсэн 5.0 оноо
- ✓ Тайланг ирүүлээгүй 0.0 оноо

4. Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээний гаргалт, үнэн бодит байдал, хугацааг харгалзан 0-24.0 оноо

- ✓ Тайланг хугацаандаа, үнэн зөв ирүүлсэн 2.0 оноо (сар бүр)
- ✓ Тайланг хугацаандаа, үнэн зөв ирүүлээгүй 0.0 оноо

5. Аудитын дүгнэлт 0-20.0 оноо

- ✓ Зөрчилгүй дүгнэлт 20.0 оноо
- ✓ Зөрчилтэй дүгнэлт, хязгаарлалттай дүгнэлт, дүгнэлт өгөхөөс татгалзсан 0.0 оноо

V. ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ

5.1. Шалгуур үзүүлэлт тус бүрийг тооцсоны дараа хавсралтад тусгагдсан шилжүүлэх илтгэлцүүр (коэффициент)-ийн тусламжтайгаар хөрвүүлэн тооцож Ш1-Ш16-ийн нийлбэрээр үр дүнгийн үзүүлэлтийг тооцно.

5.2. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээг хариуцан боловсруулах, түүнд хяналт тавих газар, нэгжийг хавсралтад тусгасан.

----- оОо -----

ХАВСРАЛТ

Шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах үндсэн оноо, шилжүүлэх коэффициент, хариуцах газар, нэгж

Тухайн жилийн зорилго, зорилтыг харгалзан тухайн бүлэгт ± 3 хүртэл өгч болно.

Код	Шалгуур үзүүлэлт	Үндсэн оноо			Хариуцах газар
		Үндсэн оноо	Аргачлалын оноо	Шилжүүлэх коэффициент	
I БҮЛЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭНИЙ БОДИТ БАЙДАЛ, ХАМРАЛТ, ДАМЖУУЛАЛТ - 43.0 ОНОО					
Ш1	Мэдээний хамралт	7	100	0.06	МЭЗСГ, ХАНСГ
Ш2	Мэдээний дамжуулалт	5	100	0.06	МБТГ
Ш3	Мэдээний бодит байдал, чанар	12	100	0.12	МЭЗСГ, ХАНСГ
Ш4	Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сан	10	100	0.1	МБТГ
Ш5	Бизнес регистрийн мэдээллийн сан	9	100	0.09	МЭЗСГ
II БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ ЧАНАР ҮР ДҮН - 28.0 ОНОО					
Ш6	Мал тооллого	8	100	0.07	МЭЗСГ
Ш7	ӨНЭЗС	7	100	0.07	ХАНСГ
Ш8	АХС	7	100	0.07	ХАНСГ
Ш9	Эдийн засгийн түүвэр судалгаа	6	100	0.07	МЭЗСГ
III БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ - 13.0 ОНОО					
Ш10	Сургалтын үйл ажиллагаа	3	50	0.08	МССТ
Ш11	Сурталчилгаа	3	50	0.06	МССТ
Ш12	Вэб баяжилт	3	100	0.03	МССТ
Ш13	Мэдээлэл тархаалт	4	100	0.03	МССТ
IV БҮЛЭГ. ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА - 16.0 ОНОО					
Ш14	Төлөвлөлт, тайлагналт	5	100	0.05	ТЗУГ
Ш15	Хяналт үнэлгээний үр дүн, өгөөж	5	100	0.06	БХЗГ
Ш16	Санхүүгийн үйл ажиллагаа	6	100	0.05	ТЗУГ
БҮЛГҮҮДИЙН НЭГДСЭН ДҮН		100.0			

ЖУРМЫН ТӨСЛИЙГ ХЯНАСАН:

Ажлын хэсгийн дарга

Т.Гантөмөр Ерөнхий менежер

ЖУРМЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛСАН:

Гишүүд:

Б.Ганбат

БХЗГ-ын дарга

Л.Мягмарсүрэн

МБТГ-ын дарга

Э.Эрдэнэсан

МЭЗСГ-ын дарга

Б.Саранчимэг

ХАНСГ-ын орлогч дарга

А.Дэмбэрэл

МССТ-ийн дарга

Ш.Оюунгэрэл

ТЗУГ-ын ахлах шинжээч

Б.Оюундэлгэр

ТЗУГ-ын шинжээч

Г.Батбуян

МССТ-ийн шинжээч

ЖУРМЫН ТӨСЛИЙГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Нарийн бичгийн дарга:

Л.Энхбаатар

ТЗУГ-ын ажилтан

2014.06.13